

ТАНИЛЦУУЛГА

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ, ХАРЬЯА АГЕНТЛАГТ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоолын хүрээнд Зам, тээврийн яам, агентлага болон холбогдох албан тушаалтанд 2025 оны эхний хагас жилд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн танилцуулж байна.

1. Зам, тээврийн яам болон харьяа Иргэний нисэхийн ерөнхий газарт 2025 оны эхний хагас жилд нийт **945** иргэн өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн **100**, хяналтад хугацаа болоогүй **38** өргөдөл, гомдол, шийдвэрлэлт **96%**-ийн үзүүлэлттэй байна.

2. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2025 оны эхний хагас жилд Зам, тээврийн яаманд **590**, Иргэний нисэхийн ерөнхий газарт **27**, нийт **617** гомдол, санал, хүсэлт ирүүлсэн бөгөөд шийдвэрлэлт **81,2%**-тай байна.

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн гомдлын дийлэнх хувийг авто тээврийн үндэсний төвийн ажиллах хүч, цагийн хуваарь, хот хоорондын нийтийн тээврийн тасалбар буцаалт, ачаа тээвэр, хүнд даацын авто машины тонн жингийн стандарт, төлбөр хураах цэгийн төлбөр, шилжилт хөдөлгөөн, авто машины дугаарын худалдаа, үйл ажиллагаатай холбоотой гомдлууд эзэлж байна.

Зам, тээврийн яам болон харьяа Иргэний нисэхийн ерөнхий газарт хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хувьд шагнал урамшуулал, байгууллагын үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдөл дийлэнх хувийг эзэлж байна.

Зам, тээврийн яам болон харьяа Иргэний Нисэхийн ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хүснэгтээр хавсаргав.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

2025 оны эхний хагас жил

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын төрөл				Хүлээн авсан хэлбэр				
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биеэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөөс шилжүүлсэн	Албан бичгээр
	1	2		3	4				5
Тайлбар:	Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, аппликэйшн, сошиал флатформ, мэйл г.м	11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Зам, тээврийн яам	3	6	12	161	177	3	5	0	0
Зам, тээврийн яам (11-11 төв)	2	236	159	193	0	0	0	590	0
ИНЕГ	4	30	83	56	146	0	0	27	0
НИИТ	9	272	254	410	318	3	7	617	0
				945					945

2025 оны эхний хагас жил

ЗТХЯ
ИНЕГ
НИЙТ

Шийдвэрлэлтийн байдал									
Шийдвэрлэж хариу өгсөн				Бусад байгууллагад шилжүүлсэн		Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /30 хоног/	Сунгалт хийсэн боловч хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн /60 хоног/	Хугацаа болоогүй	Шийдвэрлэх боломжгүй
Албан бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Харьяаллын дагуу шилжүүлсэн тоо	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо				
99	32	590	51	578				17	0
45		27	101	20				21	0
144	32	617	152	598				38	0
				945					38

2025 оны эхний хагас жил

Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
Авто тээвэр, авто тээврийн үндэсний төв	351	37.1	Авто тээврийн үндэсний төвийн үйл ажиллагаа, үзүүлдэг үйлчилгээний талаар иргэдэд сурталчилах. Хот хоорондын нийтийн тээврийн дүрэм журмын талаар нийтэд сурталчилах. Автотээврийн үндэсний төвийн үйл ажиллагаанд анхаарч, нийтэд мэдээлэл хүргүүлэх.
Авто зам, төлбөр хураах цэг, зам тээврийн хөгжлийн төв	275	29.1	Замын орц гарц гаргах тухай, төлбөр хураах цэгийн дүрэм журмын талаар нийтэд танилцуулах.
Иргэний нисэх, МИАТ	29	3.1	Үйл ажиллагаандаа анхаарах болон авиа компаниудын хяналт.
Төмөр зам	44	4.7	Мал амьтан дайрагдах эрсдэл, хөдөлмөрийн харилцаа болон УБТЗ-ын эмнэлэгийн үйл ажиллагаанд анхаарах.
Шагнал, урамшуулал хүсэх тухай	51	5.4	Цол, тэмдэгийн мөнгөн тэтгэмж, гээгдүүлсэн тэмдэг нөхөн олгох дүрэм журам, зааврыг нийтэд сурталчилах.
Бусад	195	20.6	Иргэдэд салбарын мэдээллийг хүргэх, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих.

945 100.0